

ӨВЧТӨНГ ЭДГЭЭХ НЬ



Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүкс гайхамшгууд тохиоход итгэл нэн чухал гэдгийг заасан байдаг:

“Итгэл нь тэнгэрийн хүчээр эдгээхэд зайлшгүй шаардлагатай. Түүнчлэн Мормоны Номонд ‘хэрэв хүмүүний үрсийн дунд итгэл үгүй бол Бурхан тэдний дунд ямар ч гайхамшгийг үйлдэж эс чадах буюу’ хэмээн заадаг (Ифер 12:12) [1 Нифай 7:12; С ба Г 35:9]. Өвчтөнүүдэд үйлчлэх талаар өгсөн онцгой үгэндээ ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл: ‘Итгэлтэй байх шаардлагыг ихэвчлэн чухалчилж үздэггүй. Хамгийн том үүрэг хариуцлага адислал авч байгаа хүнд байх ёстой байтал өвчтэй хүн болон гэр бүлийнхэн нь ихэнхдээ зөвхөн ёслол гүйцэтгэж буй ах нарын санваарын хүчинд болон тэдэнд байгаасай хэмээн найдаж буй эдгээх бэлэгт найдсан байдаг. . . . Хамгийн чухал зүйл нь өвчтөн сэрүүн, хариуцах чадвартай байгаа үедээ итгэлтэй байх явдал юм. “Итгэл чинь чамайг эдгээлээ” [Матай 9:22] гэсэн үгсийг Эзэн олон удаа давтан хэлсэн байдаг бөгөөд энэ нь бараг уншлага болжээ’ [“President Kimball Speaks Out on Administration to the Sick,” *New Era*, 1981 оны 10-р сар, 47]” (“Өвчтөнг эдгээх нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 5-р сар, 49).



Ахлагч Даллин Х.Өүкс итгэлтэй байхын нэг чухал хэсэг бол Бурханы хүслийг хүлээн зөвшөөрөх гэдгийг бидэнд бас сануулсан байдаг.

“Бид Бурханы санваарын хүчийг эргэлзээгүйгээр ашиглан, мөн Тэр биднийг итгэлтэйгээр залбирах үед сонсож, хариулах болно хэмээсэн Түүний амлалтыг эрхэмлэн дээдэлвээс итгэл болон санваарын хүч нь Түүний хүслийн эсрэг үр дүнд хүргэнэ гэж байхгүй. Учир нь энэ санваар Түүнийх. Энэ зарчмыг өвчтөн дээр гар тавихад Сүмийн ахлагчдад удирдамж өгсөн илчлэлтэд заасан байдаг. Надад ‘эдгэрэх итгэлтэй

мөн үхэлд оноогдоогүй тэр нь эдгэрэх болно’ (С ба Г 42:48, онцлон тэмдэглэлт нэмэгдсэн)” хэмээн Их Эзэн амласан билээ. Үүний адил өөр нэгэн орчин үеийн илэрхийлэлд Их Эзэн хэн нэгэн ‘Бурханы тааллын дагуу асуувал . . . энэ нь бүр түүний асуусанчлан үйлддэг болой’ хэмээн тунхаглажээ (С ба Г 46:30) [1 Иохан 5:14; Хиламан 10:5-ыг бас үзнэ үү].

“Энэ бүхнээс харахад, эдгэрэх хангалттай итгэлтэй байхад Их Эзэний үйлчлэгчид Түүний тэнгэрлэг хүч чадлыг ашигласан ч Их Эзэний хүсэлд нийцээгүй бол уг хүнийг эдгээх санваарын адислалыг өгч чадахгүй гэдгийг бид олж мэдэх юм.

“Бид Бурханы үр хүүхдийн хувьд, Түүний агуу хайрыг мөн бидний мөнхийн сайн сайханд юу хэрэгтэй болох талаар Тэр төгс мэдлэгтэй гэдгийг мэддэг учраас бид Түүнд итгэдэг. Сайн мэдээний анхны зарчим бол Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл бөгөөд итгэх гэдэг нь найдах гэсэн үг юм. Хүнд өвчнөөс болж нас барсан арван хэдхэн настай охины оршуулга дээр үеэл маань үг хэлэхэд би тэр найдварыг мэдэрсэн юм. Эхлээд намайг гайхахад хүргэж, мөн дараа нь гэгээрүүлсэн дараах үгсийг тэр хэлсэн: “Түүний насан өөд болсон нь Их Эзэний хүсэл байсан гэдгийг би мэднэ. Тэр эмнэлгийн сайн эмчилгээг хийлгэсэн. Түүнд санваарын адислал өгөгдсөн. Түүний нэр ариун сүмийн залбирлын нэрсийн жагсаалтад ч байсан. Түүний эрүүл мэндийн төлөө олон зуун залбирал хэлэгдсэн байв. Энэ үед түүнийг гэртээ аваачих нь Их Эзэний хүсэл байгаагүйсэн бол түүнийг эдгээх хангалттай их итгэл тэр гэр бүлд байсан гэдгийг би мэднэ.” Би мөн арван хэдэн настайдаа хавдраар нас барсан өөр нэгэн сонгогдсон охины эцгийн үгнээс мөн үүнтэй адил найдварыг мэдэрсэн юм. Тэрээр ‘манай гэр бүлийнхний Есүс Христэд итгэх итгэл үр дүнгээс нь хамаардаггүй’ гэж тунхагласан. Тэдгээр сургаал миний хувьд үнэн юм. Бид хайртай нэгнийгээ эдгээхийн тулд чадах бүхнээ хийж, дараа нь үр дүн нь ямар байхыг Их Эзэнд найддаг билээ” (“Өвчтэйг эдгээх нь,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 5-р сар, 50).